



АРХАНГАЙ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2019/11




[www.nso.mn](http://www.nso.mn) [www.arkhangai.nso.mn](http://www.arkhangai.nso.mn) [www.1212.mn](http://www.1212.mn)



## ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 99 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 262.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 101.5 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 17.5 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100.0 хувь хамруулсан байна.



Оны эхний 11 сард 1562 эхээс 1570 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 1.4 хувиар буюу 23 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 505 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 25 тохиолдлоор буюу 5.0 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 16.4, нас баралт 5.3 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 11.1 промил байна. Оны эхний 11 сард эхийн

эндэгдэл 1 гарсан, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 11 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 9.0 хувиар их байна.

Нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 25 гарч мянган амьд төрөлтөд 16 ногдож байгаа нь өнгөрсөн оныхоос 5 тохиолдлоор буурсан байна.

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 50 нь буюу 483 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Булган (98) Эрдэнэбулган (94), Цэнхэр (57), Ихтамир (55), Тариат (58) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 8.5 хувь нь салхин цэцгээр, 16.6 хувь нь цусан суулга, 54.6 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 10.5 хувь нь сүрьеэгээр, 9.8 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 3.6 хувиар буюу 18 тохиолдлоор буурсан байна.




## АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

12 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1022 ажилгүй хүн байгаагийн 53.4 хувь нь буюу 546 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 173 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 9.0 хувиар өссөө байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.1 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 172 нь дээд, 37 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 772 нь бүрэн болон бүрэн бус дунд, 32 нь бага боловсролтой хүмүүс байна.

11 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 417 хүн шинээр бүртгүүлж, 341 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болсон байна. Харин 103 хүн ажилд зуучлуулан орсон байна.

### Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо



Оны эхний 11 сард аймгийн дүнгээр 947 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 183, Эрдэнэмандал, Өндөр-улаан, Тариат, Төвшрүүлэх, Цэнхэр, Хангай, Булган сумд 51-87 ажлын байрыг, Хотонт, Цэцэрлэг, Чулуут сумд 37-49 ажлын байрыг, Жаргалант, Батцэнгэл, Өгийнуур, Хашаат, Цахир, Хайрхан, Өлзийт, Цахир сумд 10-25 ажлын байрыг тус тус бий болгожээ.



## **НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ**

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 11 сард 56.6 тэрбум төг, зарлага 47.4 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 9625.8 сая төг буюу 20.5 хувиар, зарлага 5754.6 сая төг буюу 14.1 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 9625.8 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 21.4 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 7.0 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 7.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 14.1 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 15.3 хувиар, тэтгэмжийн даатгалын зарлага 10.0 хувиар өссөн нь нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 37.2 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1765.6 сая төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс олгосон тэтгэврийн хэмжээ 14.1 хувиар, тэтгэмжийн хэмжээ 18.7 хувиар өссөн байна.

Оны эхний 11 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 42.5 мянган хүнд 13266.8

сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 48.0 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 45.3 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна. Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 54.5 хувийг халамжийн тэтгэврээр, 33.1 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 12.4 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

**Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц**




## ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 321 холбогдогч бүхий 584 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 148, өмчлөх эрхийн эсрэг 314, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 46, байгаль хамгаалах журмын эсрэг 21, бусад 25 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 32 хүн нас барж, 182 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 2048.4 сая төгрөгийн хохирол


учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 7.0 хувийг бүлэглэж 21.6 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 618 хүнийг албадан саатуулж 360 хүнийг баривчилсан байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 18.5 хувиар буюу 91 тохиолдлоор нэмэгдсэний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 1.0 хувиар буурсан бол өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 30.3 хувиар, нэмэгдсэн байна.

**Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**






## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2019 оны эхний 11 сард аймгийн төсөвт 17272.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 18330.3 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 106.1 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 7122.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 8180.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 114.9 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Ихтамир, Хангай, Тариат, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Өгийннуур, Хашаат, Батцэнгэл, Төвшрүүлэх, Хотонт, Эрдэнэбулган, Цахир, Булган сумд 102.8 хувиас 2 дахин биелүүлсэн байна. Харин Өндөрүлаан, Цэнхэр, Чулуут сум 2.5-6.8 хувиар тасалсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар




Орлогыг нэр төрлөөр нь үзвэл хог хаягдалын үйлчилгээний хураамж, рашаан ус ашигласны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, газрын дуудлага худалдаа,

бууны татвар, ойгоос мод түлээ ашигласны төлбөрөөс бусад нэрийн орлогуудыг 101.9 хувиас - 2.2 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 55.4 хувийг тусламжийн орлогоор, 28.0 хувийг орлогын албан татвараар, 1.5 хувийг өмчийн татвараар, 2.0 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 5.2 хувийг бусад албан татвараар, 6.3 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 262.1 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 969.7 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 27.0 сая төгрөг бүгд 1258.8 сая төгрөгийг шилжүүлж төлөвлөгөөг 163.9 хувиар биелүүлэв..

**Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар**



Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 58100.1 сая төгрөг байгаагийн 59.4 хувийг цалин хөлсөнд, 7.4 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 33.2 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 28.7 хувийг орон нутгийн засаг захиргаанд, 58.2 хувийг боловсролын салбарт, 11.8

хувийг эрүүл мэндийн салбарт, 0.8 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.5 хувийг бусад салбарт зарцууллаа.




## МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 22.6 тэрбум төгрөгийг авч 32.1 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 11 сард банкууд 48.7 мянган иргэд, аж ахуй нэгжид 116.3 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 46 хүнд 1266.9 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар тэрбум.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 16.4 хувиар өсч, олгосон зээлийн хэмжээ 15.3 хувиар буурч мөн анхаарал хандуулах зээлийн хэмжээ 17.3 хувиар буурч, чанаргүй зээлийн хэмжээ 20.0 хувиар нэмэгдсэн байна.



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2019 оны 11 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0.5 хувиар өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.1 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 10 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан бараа үйлчилгээний үнэ тарифын 9.1 хувийнх нь өсч, 1.9 хувийнх нь үнэ буурч, 89.0 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас байцаа, сонгино, ургамлын тос, хонины махны үнэ 1.7 – 13.3 хувиар буурч харин өндөг, жигнэмэг, данх лаа, эмэгтэй куртик, өвлийн гутал зэргийн үнэ 0.8 – 13.3 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 30.5 хувийнх нь буюу 114 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 12.1 хувийнх нь буюу 45 нэрийн барааны үнэ буурч, 57.4 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс дотор дотор мах, өөхөн тос, хатаасан жимс, шүдэнз, элсэн чихэр, эдийн саван, ноосон цамц зэргийн үнэ 0.4 – 36.2 хувиар буурч, харин цагаан будаа, гоймон, хиам, шар будаа, адууны мах, будаа агшаагч, зөгийн бал, ариун цэврийн цаас, шоколад, цемент, тосон будаг, хүүхдийн жинсэн өмд, эмэгтэй савхин бээлий зэрэг барааны үнэ 0.4 – 55.5 хувиар нэмэгдсэн байна.



## ХӨДӨӨ АЖ АХУЙ


12 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 84.6 хувь нь буюу 2002 мянган эх мал төллөж гарсан төлийн 97.2 хувь нь буюу 1945.1 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 100 хувь,

унаганы 96.7 хувь, тугалын 97.5 хувь хурганы 97.6 хувь, ишигний 96.2 хувь нь бойжиж байна.



Сумдаас Төвшрүүлэх, Өгийнуур сумдад төлийн хорогдол гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 10.4 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 14.2 хувиар их байгаа бол төлийн хорогдол 2.2 дахин бага байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Оны эхний мал 99.2 хувиар онд орж оны эхний малын 0.8 хувь буюу 44.8 мянган том мал хорогдов. Хорогдсон

малын 6.2 хувийг адуу, 8.9 хувийг үхэр, 57.7 хувийг хонь, 27.2 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Эрдэнэмандал, Өндөр-Улаан, Цахир, Жаргалант, Ихтамир сумдын оны эхний малын 1.1- 2.0 хувь нь, Өгийнуур, Төвшрүүлэх, Хашаат, Хотонт сумд том малын хорогдол гаргаагүй, бусад сумдын малын 0.4-1.0 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Энэ хавар 9040.0 га-д үр тариа, 264.3 га-д төмс, 126.5 га-д хүнсний ногоо, 1097.9 га-д малын тэжээлийн ургамал, 700 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 30.7 хувиар, төмс 4.9 хувиар, хүнсний ногоо 20.9 хувиар их харин техникийн ургамал 40.5 хувиар, тэжээлийн ургамал 37.2 хувиар бага тариалсан байна.

Энэ онд аймгийн дүнгээр үр тариа 10581 тн, төмс 2442.4 тн, хүнсний ногоо 1182.2 тн, тэжээлийн ургамал 2730.4 тн, техникийн ургамал 810 тонныг хурааж, байгалийн хадлан 74.5 мянган тн, гар тэжээл 1040.2 тонныг бэлтгээд байна.


2019 онд манай аймаг ойгоос 93.2 мянган м3 галын түлээ, 10.6 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 103.9 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 11 сард 70.6 мянган м3 галын түлээ, 8.2 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 78.5 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 250.8 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



Үйлдвэрийн газрууд 2019 оны эхний 11 сард оны үнээр 5668.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 5576.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос 3.0 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 1936.5 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.9 хувиар илүү байна.

Нийт үйлдвэрлэлтийн 13.0 хувийг хүнс ундааны, 1.5 хувийг хэвлэлийн, 57.3 хувийг дулааны эрчим хүчний, 14.0 хувийг усан хангамж, 3.8 хувийг модон эдлэлийн, 7.6 хувийг гутал хувцасны, 2.9 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, бүтэц, хувиар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлснээр гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, бууз, савласан цэвэр ус, түгээсэн цэвэр ус, хэрчсэн гурил, хүснэгт, эмээлийн мод, вакуум цонх үйлдвэрлэлт 106.0 хувиас 176.4 хувиар өссөн байна. Харин, хэрчсэн гурил, зүсмэл, түгээсэн цэвэр ус, савхин гутал, монгол дээл, гэрийн модон тавилганы үйлдвэрлэлийн хэмжээ 0.8 – 65.8 хувиар буурсан байна.

Тээврийн байгууллагууд 43.6 мянган зорчигч, 75.0 мянган тонн ачаа тээвэрлэн 20.3 сая хүн км, 10.4 сая ткм ажил гүйцэтгэн 661.2 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт, ачаа эргэлт, орлогын хэмжээ 6.6 -14.4 хувиар буурсан байна.

Холбооны байгууллагууд 395 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 267.9 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.9 хувиар өссөн байна.



## ЦАГ УУРЫН БАЙДАЛ

11 дүгээр сард агаарын дундаж температур – 7.0-өөс - 11.3 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Батцэнгэл, Хашаат, Төвшрүүлэх, Хотонт, Эрдэнэбулган сумдад 14.0-ээс 16.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Хангай, Тариат, Цахир, Өндөрүлаан, Өлзийт, Булган сумдад –28.0-аас –31.0 хэмд хүрч хүйтэн байсан байна.

11 дүгээр сард Эрдэнэбулган, Жаргалант, Төвшрүүлэх, Тариат, Хашаат сумдын нутгаар 4.5 – 6.6 мм тундас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хангай, Өндөр-улаан, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Батцэнгэл, Хотонт, Цахир сумдад 0.6 - 1.8 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

**Статистикийн хэлтэс**  
**2019.12.16**